

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Тогтвортой, тэсвэртэй байдлыг хадгалах нь



Тусгай сэдэв: Улаанбаатар хотын төвлөрөл ба бүтээмж

ХУРААНГУЙ



ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП

2026 оны 4 сар

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

*Тогтвортой, тэсвэртэй байдлыг
хадгалах нь*

2026 оны дөрөвдүгээр сар

© 2025 Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк / Дэлхийн банк
1818 Н гудамж, NW
Вашингтон ДС 20433
Утас: 202-473-1000
Интернет: www.worldbank.org

Энэхүү тайлан нь Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн бүтээл бөгөөд бусад гаднын байгууллагууд хувь нэмэр оруулж хамтарсан. Тайланд тусгасан үр дүн, тайлбар, дүгнэлт зэрэг нь Дэлхийн Банк, Дэлхийн Банкны Гүйцэтгэх Захирлууд болон тэдний төлөөлж буй улс орнуудын Засгийн газрын байр суурийг илэрхийлэх албагүй болно.

Дэлхийн Банк энэ тайланд дурдагдсан мэдээ мэдээллийн үнэн бодит, бүрэн, сүүлийн үеийн эсэхэд баталгаа өгөхгүй бөгөөд аливаа мэдээллийн хувьд гарсан алдаа, орхигдуулга, зөрүүтэй байдал, уг мэдээллүүд, аргачлал, үйл явц болон дүгнэлтийг ашиглах болон эс ашиглахтай холбогдуулан бий болох зөрчилд хариуцлага хүлээхгүй болно. Уг бүтээлд ашиглагдсан хил хязгаар, өнгө, үг хэллэг, линк, нэмэлт тайлбарууд болон бусад мэдээлэл нь Дэлхийн Банкны зүгээс аливаа бүс нутгийн хууль ёсны хил хязгаарт санал бодлоо илэрхийлэх, зөвшөөрч байгаа явдал биш болно. Бусад гадны мэргэжилтнүүдийн бүтээлийг энэ тайланд иш татаж байгаа нь Дэлхийн Банкны зүгээс тэдгээрийн илэрхийлж буй санал бодол, бүтээлийн агуулгыг сурталчилж байгаа явдал биш болно.

Үүнээс цааш дурдагдаж байгаа бүх мэдээлэл Дэлхийн Банкны бүрэн халдашгүй эрхээс ангид байх болно.

Эрх ба зөвшөөрөл

Энэ бүтээл нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан. Дэлхийн Банкнаас өөрийн мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхийг хөхиүлэн дэмждэг бөгөөд бүрэн хэмжээнд иш татсан, зах зээлийн ашиг олохоос бусад тохиолдолд хэсэгчлэн болон бүтнээр уг бүтээлийг дахин ашиглах боломжтой.

Энэхүү бүтээлийн эрх ба зөвшөөрлийн талаар дараах хаягаар хандана уу: Дэлхийн Банкны Хэвлэлийн Алба, Дэлхийн Банк Групп, 1818 Н Гудамж NW, Вашингтон ДС 20433, АНУ; факс: 202-522-2625; имэйл: pubrights@worldbank.org.

Хавтас, бүлгүүдийн зураг: © Жамбалын Батбаатар /Баку Дизайн. Жамбалын Батбаатарын зөвшөөрөлтэйгөөр ашигласан. Дахин ашиглахын тулд нэмэлт зөвшөөрөл шаардлагатай.
Тайлангийн загвар: Баку Дизайн

ХУРААНГУЙ

Бүлэг 1: Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөв

Олон улсын худалдааны тасалдал, геополитикийн хурцадмал байдал өндөр хэвээр байсан ч Монгол Улсын эдийн засаг 2025 онд 6.9 хувиар өслөө. Энэхүү өсөлтийг зудын дараах хөдөө аж ахуйн салбарын сэргэлт, уул уурхайн салбарын өндөр гүйцэтгэл голлон бүрдүүлэв. Уул уурхайн салбарын хувьд нүүрстэй холбоотой идэвхжил буурсан, гэвч нөгөө талаас Оюу Толгойн зэсийн үйлдвэрлэл өсөлтийг голлон тэтгэлээ. (Зураг Х.1). Уул уурхайн бус салбарын хувьд өсөлт ерөнхийдөө сул буюу барилга, боловсруулах салбар өндрөөр өссөн боловч худалдаа, үйлчилгээний бусад салбаруудын өсөлт харьцангуй бага байв.

Хөдөө аж ахуй, аж үйлдвэрлэлийн дээрх идэвхжил нь өрхийн орлого, хувийн хэрэглээ, экспортыг дэмжлээ. Хувийн хэрэглээ харьцангуй өндөр өсөлттэй гарч, эрэлтийн гаралтай инфляцын дарамтад нөлөөллөө. Түүнчлэн, хүнсний болон эрчим хүчний үнийн өсөлтөөс үүдэлтэй нийлүүлэлтийн дарамт мөн нэмэгдэж, инфляц дунджаар 8.6 хувьтай гарлаа. Гэвч хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал суларч, бодит орлого, хэрэглээний зээлийн өсөлт удааширч байгаатай холбоотойгоор хэрэглээний өсөлтийн эрч оны сүүлийн хагаст алгуур саарчээ (Зураг Х.2). Зэсийн экспорт нэмэгдсэнээр цэвэр экспорт өсөж, эдийн засгийн өсөлтийг тэтгэв. Үндсэн хөрөнгийн хуримтлалыг төрийн өмчит аж ахуйн нэгжүүд (ТӨААН)-ийн дэд бүтцийн төслүүд дэмжсэн ч Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт дуусах дөхөж байгаатай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ын орох урсгал саарсан, мөн материаллаг эргэлтийн хөрөнгө огцом буурсан нь хөрөнгө оруулалтыг бууруулж, ДНБ-ий өсөлтөд сөргөөр нөлөөллөө.

Худалдааны тэнцэл сайжирч, үйлчилгээний дансны алдагдал буурснаар урсгал тэнцлийн алдагдал хумигдав. ГШХО-ын орох урсгал удааширсан ч гадаад зээл нэмэгдсэнээр, гадаад валютын нөөц нэмэгдэхэд нөлөөллөө. Бараа бүтээгдэхүүний экспорт харьцангуй тогтвортой байв. Нүүрсний экспортын орлого үнийн уналтаас шалтгаалан огцом буурсан ч Оюу толгойн зэсийн үйлдвэрлэл болон үнэ өсөж, нүүрсний экспортын орлогын уналтыг нөхлөө. Нөгөө талаас зээлийн нөхцөл чангарч, хөрөнгө оруулалт удааширч байгаатай холбоотойгоор удаан эдэлгээтэй болон хөрөнгө оруулалтын бараа бүтээгдэхүүний эрэлт буурснаар бараа бүтээгдэхүүний импорт агшлаа. Импортын хэмжээ ийнхүү агшсан нь ачаа тээврийн үйлчилгээний импорттой холбоотой гарах урсгалыг бууруулж, үйлчилгээний дансны алдагдлыг хумихад нөлөөлөв. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр урсгал дансны алдагдал ДНБ-ий 4.4 хувьд хүрч буураад байна (Зураг Х.3). Улмаар, нийт гадаад валютын улсын нийт нөөц 2025 оны 12 дугаар сарын эцэст импортын 4.7 сар болж өссөн нь өмнөх оны мөн үеийн 3.7 сараас өссөн үзүүлэлт юм.

Төсвийн орлого тасалдаж, дүрмийн дагуу зардлыг танах шаардлагын хүрээнд төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын зардлуудыг хумив. Төсвийн нийт орлого ДНБ-ий 35.3 хувьд хүрч, 2024 оны түүхэн дээд хэмжээ болох 39.2 хувиас буурлаа. Үүнд нүүрсний үнэ огцом буурч, уул уурхайн салбараас олох орлого саатсан нь голлон нөлөөлсөн бол худалдааны салбарын идэвхжил саарсан нь мөн уул уурхайн бус салбарын орлогыг буурууллаа. Төсвийн дүрмийн хүрээнд төсвийн зардлыг 2025 онд өмнөх жилтэй харьцуулахад ДНБ-ий 38.1 хувиас 33.8 хувьд хүргэж мэдэгдэхүйц хэмжээгээр хязгаарласан. Ингэхдээ анх өргөн барьсан төсөв болон төсвийн тодотголын хүрээнд зардлыг танах, тэр дундаа төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах замаар хэрэгжүүлжээ (Зураг Х.4).

Түүнчлэн, дэд бүтцийн бүтээн байгуулалтуудыг төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээр дамжуулан хэрэгжүүлэх нь түгээмэл болж байна. Монгол Улсын төсвийн ерөнхий тэнцэл 2025 онд ДНБ-ий 1.5 хувьтай тэнцэх хэмжээний ашигтай гарч, баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэв. Мөн, улсын өр ДНБ-ий 40.2 хувьд хүрч (өнгөрсөн оны 42.8 хувиас) буурахад эдийн засгийн өсөлт өндөр, төсвийн ерөнхий тэнцэл ашигтай гарсан зэрэг нь голлон нөлөөллөө. Ийнхүү сүүлийн жилүүдэд төсвийн ерөнхий тэнцэл ашигтай гарч, зардал болон улсын өр бууран, эдийн засаг тогтвортой өсөж байгаа нь улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, зах зээлийн итгэлийг нэмэгдүүлэх, зээлийн нөхцөл зөөлрөхөд чухал дэмжлэг болж байна.

Мөнгөний болон макро зохистой бодлогыг чангаруулсан нь эрэлтийн шинжтэй инфляцын дарамтыг сааруулах, мөн валютын ханшийн уян хатан бодлого нь валютын нөөц хуримтлуулах замаар гадаад орчны тохируулгыг хийхэд дэмтэй байв. Бодлогын хүү өндөр байж, өр-орлогын харьцааг чангаруулсан нь бодит хүүг өсгөн, зээлийн өсөлтийг сааруулж, ялангуяа өрхийн хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарласнаар эрэлтийн шинжтэй инфляцын дарамтыг алгуур бууруулахад нөлөөллөө. Үүний зэрэгцээ, валютын ханшийн уян хатан байдлыг нэмэгдүүлж, гадаад валютын зах зээл дэх оролцоог бууруулсан нь төгрөгийн ханшийг сулруулж, гадаад валютын нөөцийг мөн дэмжсэн байна.

Дэлхийн зах зээлд эрчим хүчний үнэ өсөж, Ойрх Дорнодын мөргөлдөөнтэй холбоотойгоор геополитикийн тодорхой бус байдал өндөр байгаа ч Монголын эдийн засгийн өсөлт 2026 онд тогтвортой хадгалагдах төлөвтэй байна. Тодруулбал, уул уурхай болон хөдөө аж ахуй салбар тогтворжиж эдийн засаг 5.0 хувиар өсөх хүлээлттэй байна. Харин уул уурхайн бус салбарын үйл ажиллагааг дэд бүтцийн бүтээн байгуулалт, үйлчилгээний салбар дэмжих төлөвтэй (Хүснэгт Х.1). Өндөр инфляц, цалингийн бага өсөлт, бодлогын хатуу төлөв зэрэг нь хувийн хэрэглээг сааруулах ч, хувийн хэрэглээ харьцангуй өндөр түвшинд хадгалагдах төсөөлөлтэй. Нөгөө талаас, төрийн өмчийн байгууллагууд болон Улаанбаатар хотын төслүүд нь төрийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эдийн засагт гол түлхэц болохоор байна. Хувийн хөрөнгө оруулалт бизнесийн зээлээр дэмжигдэх төлөвтэй байгаа ч Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт дууссанаар, ГШХО саарах төлөвтэй байна. Дунд хугацаанд (2027-28) дэд бүтцийн томоохон төслүүд болон дотоод эрэлтийн тогтвортой өсөлтийг дагаад, өсөлт дунджаар 5.5 хувь орчим байх төлөвтэй.

Инфляц болон гадаад орчны дарамт нэмэгдэж, макро эдийн засгийн тэнцвэргүй байдал 2026 онд үргэлжлэх төлөвтэй. Инфляц 2026 онд шатахуун болон махны үнийн өсөлтөөс шалтгаалж 8.5 хувийн орчимд гарах төлөвтэй байгаа ч бодлогын хатуу төлөв инфляцыг бууруулах чиглэлд нөлөөлөх юм. Төсвийн бодлогын хувьд төрийн өмчийн байгууллагуудын хөрөнгө оруулалтыг тооцохгүй бол төсвийн ерөнхий тэнцэл бага хэмжээний ашигтай, улсын өр буурах чиглэлд харьцангуй тогтвортой байх төлөвтэй. Гадаад тэнцлийн хувьд нүүрсний үнэ харьцангуй хямд, импорт сэргэх зэрэгтэй уялдан урсгал тэнцлийн алдагдал тэлэхээр байгаа бол гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах, гадаад өрийн эргэн төлөлт нэмэгдэх нь санхүүжилтийн дарамтыг нэмэгдүүлэхээр байна.

Өсөлтийн төлөвийг бууруулж болзошгүй эрсдэлүүд өндөр байна. Гадаад орчин талаас, олон улсын худалдааны тодорхойгүй байдал нэмэгдэх, Ойрх Дорнодын мөргөлдөөн удаан үргэлжлэх нь гадаад эрэлтийг сулруулж болзошгүй. Энэ нь эрдэс баялгийн экспортыг бууруулж, инфляц болон үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлж, өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Нөгөө талаас, зэс, алтны үнэ өндөр байх нь экспорт болон төсвийн орлогыг нэмэгдүүлснээр уг нөлөөллийг хэсэгчлэн нөхөх боломжтой. Эцсийн дүндээ дээрх хоёр хүчин зүйлийн аль нь давамгайлах нь түүхий эдийн үнийн өсөлт болон гадаад эрэлтийн бууралтаас хамаарахаар байна. Дотоод орчны хувьд, төсвийн зардал хүлээлтээс давж өсвөл богино хугацаанд өсөлтийг тэтгэх боловч инфляцыг эрчимжүүлэх, гадаад тэнцвэрийг алдагдуулах, валютын ханшийн дарамтыг нэмэгдүүлж болзошгүй тул дунд хугацаанд бодлогын төлөвийг чангаруулах шаардлага үүсэх эрсдэлтэй. Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хувьд эерэг болон сөрөг эрсдэл аль алийг нь дагуулна. Тодруулбал, төслүүдийг богино хугацаанд хурдан хэрэгжүүлж дуусгах нь тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж, экспортыг дэмжих боломжтой ч түүхий эдийн орлого буурвал төсвийн орон зай хязгаарлагдан, төслүүдийг хойшлуулах шаардлага үүсэж, уул уурхайн бус салбарын өсөлтөд дарамт учруулж болзошгүй.


Монгол Улсын хувьд орлого буурсан, тодорхой бус байдал өндөр, эмзэг байдал нэмэгдэж байгаа өнөө үед макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, аливаа шокиг тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх нь бодлогын тэргүүлэх чиглэл болж байна. Энэ хүрээнд төсвийн сахилга бат, инфляц болон гадаад орчны нөхцөл байдлыг харгалзан мөнгөний бодлогыг хянуур байдлаар сулруулах, шатахууны үнийн өсөлтийн шокийн нөлөөг бууруулах зорилтот арга хэмжээ авах замаар макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах нь тэргүүлэх чиглэл хэвээр байна. Уур амьсгалын эрсдэл, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтворгүй байдал, сүүлийн жилүүдэд тохиосон зуд зэрэг нь макро эдийн засгийн тогтворгүй байдлыг улам бүр нэмэгдүүлж байгаа тул гамшгийн бэлэн байдлыг хангах, урамшууллын системийг сайжруулах замаар мал аж ахуйн салбарын эрсдэл даах чадварыг бэхжүүлэх шаардлагатай байна. Цаашид цөөн тооны эрдэс бүтээгдэхүүнээс хамаарах хамаарлыг бууруулахын тулд уул уурхайн бүтээгдэхүүний төрлийг өргөжүүлэх, өрсөлдөх чадвар болон бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд дэд бүтцийг бэхжүүлэх нь бодлогын тэргүүлэх чиглэл болж байна.

Бүлэг 2: Улаанбаатар хотын төвлөрөл ба бүтээмж

Улаанбаатар хотын бүтээмжийг нэмэгдүүлэхэд их хотын төвлөрсөн байдал чухал нөлөөтэй ч үүнээс бий болох үр ашиг дээд хязгаартаа хүрсэн байж болзошгүй байна. Монголын эдийн засгийн үйл ажиллагаа нийслэл хотод хэт төвлөрсөн байдаг нь нэг талаас том зах зээл дагасан эдийн засгийн боломжуудыг илтгэх ч нөгөө талаас Улаанбаатарыг чиглэсэн байнгын шилжин ирэх хөдөлгөөн, мөн уур амьсгалын шинжтэй шокийн дараах шилжих хөдөлгөөний томоохон дарамтыг бий болгодог. Монгол Улсын аж ахуй нэгж (ААН)-ийн түвшинд хийсэн судалгаагаар төвлөрөл нь бүтээмжтэй шууд хамааралтай гарсан бөгөөд салбарын өрсөлдөөн, бусад салбарын нөлөө, ойр байрлах ААН-ийн бүтээмж зэргээр дамжин нөлөөлдөг байна. Гэвч энэхүү төвлөрлөөс бий болох давуу тал нь түгжрэл, дэд бүтцийн хязгаарлалт, хотын өртөг, зардлын өсөлтөөс болж саарч эхэлж байж болзошгүй байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын хүн амын тоо цаашид нэмэгдэх нь төвлөрлөөс бий болох давуу талыг сааруулах, зарим тохиолдолд бууруулж болзошгүй юм. Энэ нь бүс нутгийн хэмжээнд ихээр төвлөрсөн зарим салбар, ялангуяа боловсруулах салбарт хүчтэй ажиглагдаж байна.

Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд Улаанбаатар хотын үр ашгийг дээшлүүлэх , орон зайн хөгжлийг тэнцвэртэй байлгах хоёрталт стратеги шаардлагатай. Энэ хүрээнд: 1) Зам, тээвэр, холболт, суурь үйлчилгээ зэрэг дэд бүтцийн шинжтэй хязгаарлалтуудыг шийдвэрлэн, түгжрэлийг бууруулах, хөдөлмөрийн хөдөлгөөнийг сайжруулах шаардлагатай. 2) Ажлын байр, орон сууц, үйлчилгээний орон зайн тархалтыг илүү сайн уялдуулах олон төвт хотын бүтэц рүү шилжиж, хот төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай. 3) Дархан, Эрдэнэт зэрэг хоёрдогч хотуудыг дэд бүтэц, ур чадвар, орон нутгийн эдийн засгийн хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтаар бэхжүүлэх нь нийслэлд ирэх ачааллыг бууруулах боломжтой. Эдгээр арга хэмжээ нь Улаанбаатар хотын төвлөрлөөс бий болох давуу талыг нэмэгдүүлж, Монголын хот суурин газруудад илүү хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг бий болгох боломжтой юм.


Зураг Х.1. ХАА-н салбарын сэргэлт, Оюу толгойн үйл ажиллагаатай холбоотойгоор 2025 оны эдийн засгийн өсөлт өндөр гарлаа



Эх сурвалж: ҮСХ.


Тэмдэглэл: Жилийн ДНБ-ий өсөлтөд эзлэх нэгж хувь

Зураг Х.2. Хувийн хэрэглээний өсөлт өндөр хэвээр байгаа ч бодит орлогын өсөлт буурч байгааг дагаад хэрэглээ мөн алгуур саарч байна




Эх сурвалж: ҮСХ, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг Х.3. Урсгал тэнцлийн алдагдал бага, гадаад зээллэг нэмэгдсэн нь валютын нөөц нэмэгдэхэд нөлөөлөв




Эх сурвалж: Монголбанк, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг Х.4. Төсвийн орлогын тасалдалтай холбоотойгоор зардлыг буурууллаа




Эх сурвалж: Сангийн Яам, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг Х.5. Инфляц 2026 оны эхэнд огцом буурахаас өмнө, 2025 оны дийлэнх хугацаанд Монголбанкны зорилтоос өндөр түвшинд тогтлоо



Зураг Х.6. Өндөр инфляц, зээлийн хурдтай өсөлтийн эсрэг мөнгөний бодлого оны турш чанга төлөвт байв



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Эх сурвалж: Монголбанк, Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Хүснэгт Х1. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

	2023	2024	2025	2026төс	2027төс	2028төс
ДНБ-ий бодит өсөлт (эцсийн ашиглалтын арга)	7.2	5.1	6.9	5.0	5.5	5.5
Инфляц (ХҮИ, хугацааны дундаж)	10.4	6.8	8.6	8.5	7.8	7.4
Урсгал дансны тэнцэл (ДНБ-ий хувь)	0.6	-10.5	-4.4	-5.4	-5.4	-5.6
Төсвийн нийт тэнцэл (ДНБ-ий хувь)	2.6	1.1	1.5	0.8	0.5	0.1
Улсын өр (ДНБ-ий хувь)	44.4	42.8	40.2	37.3	36.6	34.9

Эх сурвалж: Дэлхийн Банкны мэргэжилтнүүдийн тооцоо.

Тэмдэглэл: Улсын өрөнд Хөгжлийн Банкны гадаад зээлийг оруулсан бол Монголбанкны БНХАУ-ын Ардын банкттай байгуулсан своп хэлцлийн дүн (2025 оны эцсийн байдлаар ДНБ-ий 3.2 хувь)-г оруулаагүй болно. Инфляцыг 2020 оны хэрэглээний сагсанд суурилж тооцсон.



ДЭЛХИЙН БАНК

ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП